

# Манмин Мэдээ

№ 75 2019 оны 8 сарын 25

## “Авралын мэдээ ба эрх мэдэлт хүч, хүсэн тэмүүлж байна”

Дэлхийн өнцөг булан бүрт гэрийн цуглаан, салбар танхим, салбар сүмүүд байгуулагдсаар

Дэлхийн өнцөг булан бүрт Эзэний сайн мэдээг сонсч ивээл авсан итгэгч нарын амьдрал өөрчлөгдөж, амьд орших Бурханы эрх мэдэлт хүчийг мэдэрсэн хүмүүс нэг дор цугларч, гэрийн цуглаан, салбар танхим, салбар сүм бий болж, бүр цаашлан нэгдсэн холбоо хүртэл байгуулж дэлхий даяарх сайн мэдээний үйлс эрч хүчтэйгээр тунхаглагдаж байна.

“Би христчин телевизээр дамжуулан Итгэлийн хэмжээ сэдвээр айлдах И Жей руг пасторын сургаалийг сонсож Гондурас төдийгүй өмнөд америкийн бүх газарт ямар ч пастораас сонсож байгаагүй сүнслэг сургаалд маш их сэтгэл хөдөлсөн юм. Түүний дараа интернэтээр И Жей руг пасторын сургаалийг үргэлжлүүлэн сонсож, авралын бат итгэлтэй болж заримдаа бүр бүхэл шөнөжингөө сонсдог байлаа.”

Үүний дараанас Гондурасын Гектор Аяла итгэгч (51нас, эр) И Жей руг пасторын сургаалийг сонсдог итгэгч нар нийлээд бие биенийхээ гэрт ээлжлэн мөргөлд оролцож эхлэсэн юм. Түүнчлэн цаг орон зай үл хамаарсан И Жей руг пасторын өвчин эдгээх залбирлаар нурууны өвчин хөндүүр, арьсны өвчин зэрэг өвчнөөсөө эдгэрч Бурханы гайхамшигт хүчийг мэдэрсэн итгэгч нар цуглан, эцэстээ 2018оны 3-р сард Сан Петро сулла Манмин салбар танхимыг байгуулсан юм.

### Өмнөд Америк, Венесуел 116цуглаан Манмин хамтрахаар нэгдэв

Венесуелд ч интернэтээр дамжуулан “Загалмайн үг”, “Тэнгэрийн орон”, “Там”, зэрэг И Жей руг пасторын сургаалийг сонсож ивээл авсан Виктор Гименез итгэгч (45нас, эр) эргэн тойрондоо энэ тухай тарааж 2018оны 3-р сард Сиу дад Куаня салбар танхимыг байгуулсан юм (Зураг 1). Үүний дараахан дахин 2салбар танхим нээгдсэн юм.

Эдгээр нь Колумби Манмин цуглааны юутуб сувгаар дамжуулан гарах Эзэний өдрийн мөргөл ба өдөр бүрийн оройн даниел залбирлын цагт хамт оролцож, төрөл бүрийн өвчнөөсөө эдгэрч асуудлаа шийдвэрлүүлсэн зэрэг Ариун Сүнсний бялхам итгэлээр амьдарч байна.

Жан Жон ёон пастор (Колумби Манмин цуглаан)-г Венесуелийн хэд хэдэн мужид номлогч нарын семинар, Эдгэрэл ивээлийн цуглаан (Үйлс 19:11-12) явуулсан бөгөөд үүний үр дүнд 116цуглаан Манмины хамтарсан сүмээр бүртгэгдсэн юм.

Нэг талаар Испани хэлтэй хамгийн том христийн суваг Енласе телевизээр дамжуулан И Жей руг пасторын сургаалиар ивээл авч Бурханы хүч чадлыг мэдэрсэн үй олон хүмүүс Эзэнийг хүлээн авч, шинээр дахин төрсөн амьдралаар итгэлээр амьдарч байна.

Колумбад ч ивээл авсан итгэгч нар эргэн тойрондоо сайн мэдээг тарааж, Сун су (Зураг 2) Суга мус, Палмира, Бугара манга зэрэг газруудад 4салбар танхим бий болгосон юм. Эд нар нь одоо Колумба Манмин сүмийн юутуб шууд дамжуулалтаар Эзэний өдрийн их мөргөл ба залбиралд оролцож байна.

Орос, Молдав Манмин нэрээр нэгдсэн холбоог байгуулав



ОХУ-д алан хядах үйл ажиллагаанаас урьдчилан хамгаалах хууль, журмын дагуу шашны үйл ажиллагаа хязгаарлагдмал байдаг ч 2018оны 12-р сард Христийн сайн мэдээний хорооноос “Манмин Министр” гэх сүмийн нэгдсэн холбоог оросын хууль зүйн яам албан ёсоор бүртгэж, зөвшөөрөл олгосон байна.

Энэ нь “2003 Оросын нэгдсэн их цуглаан”-р дамжуулан И Жей руг пасторын амийн сургаал ба Бурханы эрх мэдэлт хүчийг мэдэрсэн итгэгч нар Манмин сүмтэй салбар сүмийн харилцаа тогтоосон Владимир Осипов пастор (Орос дахь Манмин салбар сүмийн ерөнхий удирдагч, Зураг 3 нүүрний эгнээний голд) Калинин град болон Баруун Уралын номлогч нартай холбогдож, Манмины үйл ажиллагааг улам өргөжүүлж байна.

Ерөнхий удирдагч нар манай чуулганд зочлон эрх мэдэлт хүчний бодит газартай танилцангаа “Манминтай хамтран оросын олон хүмүүсийг аврал руу сэрээ” гэсэн мөрөөдөлтэй болж, Владимир пастортай хамтдаа үүний төлөө итгэлээр залбирч байтал ингэж зөвшөөрөлтэй хүртэл болсон юм.

Зүүн Европын Молдав ч гэсэн И Жей руг пасторын сургаалиас ивээл авч, өөрчлөгдсөн итгэгч нарын гал халуун сайн мэдээ тараалт ба эрч хүч бүхий үйлчлэлээс гэр цуглаан бий болж, тун удалгүй салбар сүм болсон юм (Зураг 4). Саяхан мөн адил “Манмин” гэсэн нэрээр албан ёсны үйл ажиллагаа явуулах зөвшөөрлөө авсан юм.

### Энэтхэгт юутубээр 70 гэр цуглаан бий болов

Хинди шашинт Энэтхэгт ч гэрийн цуглаанууд бий болсоор байна (Зураг 5). Дели Манмин цуглааны Юутуб дамжуулалт, ‘GCNTV Хинди’ сувгийн үзэгчид И Жей руг пасторын сургаалиас маш их ивээл авч түүний өвчин эдгээх залбирлаар дамжуулан, хариулт ба эдгэрэл ерөөл авсаар байна. Түүнчлэн сар бүр маш олон тооны залбирлын хүсэлтүүд болон гэрчлэл, зөвлөгөө авах хүсэлтүүд Энэтхэг Дели Манмин цуглааны хариуцагч Ким Сан хи пастор руу ирсээр байдаг гэнэ.

Илле мужын бага сургуулийн захирал Рита итгэгч (60нас, эм) авто ослын улмаас алхаж чадахгүй тул гэртээ хэвтэж л цагыг өнгөрөөдөг байлаа. Тэгж байгаад ‘GCNTV Хинди’ сувгаар Манмин төв сүмийн 4-р сарын эдгэрэл ивээлийн цуглааныг үзэн итгэл төрсөн юм. Үүний дараахан “Загалмай үг” 24цуврал сургаалийг бүгдийг сонсч, Эзэний өдөр сахиж, эдгэрэл авах бүх бэлтгэл хийж, 5-р сарын эдгэрэл ивээлийн цуглаан үеэр алхдаг болж, гайхамшигт хүчийг мэдэрсэн юм. Энэ мэт Ариун Сүнсний гайхамшигт хүч нөлөө тасралтгүй илчлэгдэн гарч, 70гэрийн цуглаан бий болоод байна.

Гэм нүглээр дүүрсэн эцсийн энэ цаг үед өөрчлөлт болон амийг бий болгодог амийн сургаал, дагалдах тэмдэг гайхамшиг, эрх мэдэлт хүчээр бүх дэлхийн үй олон хүмүүсийг аврал руу хөтлөн дагуулах хайрын Эзэндээ бүх алдар талархалыг өргөн барья.

# Хайр бардам зан гаргадаггүй

“Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм.  
Хайр атаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй.”  
1 Коринт 13:4

И Жей руг тэргүүн пастор

Ихэнх хүмүүс бусдаас илүү дээр юмуу давуу тал байвал түүгээр өргөмжлөгдөж, хүлээн зөвшөөрөгдөх гэдэг. Ялангуяа өөрөөрөө бахархдаг хүн бусдад энэ нь яаж мэдрэгдэхэд огтхон ч анхаарахгүй бөгөөд өөрт байгаа зүйлээ ил гарах, мөн мэдүүлэхийг хүсэж онгирч сагсуурч байдгыг амархан харж болно.

“Бардамнал” гээчийг энгийнээр хэлбэл ‘Өөрийгөө илчлэх, өөрийгөө өргөмжлөх’ юм. Сайн бардамнадаг хүн бусад хүмүүсийг магтахдаа маш харам байдаг. Бусад хүмүүсийн чавдар илчлэгдэх тусам өөрөө халхлагдаж, буурай харагдаж байна гэж боддог тул яадаг ч байсан бусдыг доош татдаг байна. Тэгсээр байтал бардамнал нь бусадтай маргалдахад хүргэж, Бурханы алдрыг ч унагаахад хүргэдэг.

Энэ мэт өөрөөрөө бахархдаг сэтгэл нь бусдын эрх ашгийг хайх сүнслэг хайраас дэндүү хол байгааг илтгэдэг. Өөрөөрөө бахархагч нь өргөмжлөгдөн, хүлээн зөвшөөрөгдөж буй мэт боловч, бодит байдал дээр балчир хүүхдээс ч хайр болон хүндэтгэл авч чаддаггүй нь гачлантай. Харин ч эсрэгээрээ бусад хүмүүсийн атаа жөтөөг хөдөлгөх төдий юм (Иаков 4:16). Тийм ч учир сүнслэг хайрын дундаас “Хайр бардам зан гаргагдгүй” гэдэг зүйл маш чухал зүйл юм.

## 1. Ертөнцийг хайрлахаас үүдсэн “Амьдралын бардам бахдал”

Тэгвэл хүмүүс өөрийгөө илчлэн бахархах шалтгаан нь юу юу? Зүрх сэтгэлд “Амьдралын бардам бахдал” байгаа учраас тэр юм. “Амьдралын бардам бахдал” нь өөрийн сэтгэл хангалуун, ба зугаа цэнгэлийн төлөө өөрөөрөө онгирон сагсуурах шинж чанар бөгөөд гэмээр дүүрэн ертөнцийн зүйлсийг хайрлах сэтгэлээс үүдэлтэй гэж хэлж болох юм.

1 Иохан 2:15-16д үзвэл “Ертөнц болон ертөнцөд байгаа зүйлсийг бүү хайрла. Хэрэв хэн нэгэн нь ертөнцийг хайрладаг бол түүний дотор Эцгийн хайр байхгүй. Учир нь ертөнцөд байгаа бүхэн тухайлбал махан биеийн хүсэл тачаал, нүдний хүсэл тачаал, амьдралын бардам бахдал нь Эцгээс бус, харин энэ ертөнцөөс ирдэг юм” гэсэн байдаг юм.

Хүмүүс ихэнхдээ өөрийн чухал гэж тооцсон зүйлээрээ өөрийгөө илэрхийлж, онгирох,

бардамнах нь зайлшгүй байдаг. Мөнгийг хайрладаг хүн өөрийн баян хангалуун байдлыг, гадна төрхөө чухалчилдаг хүн гадна нүүр царайгаараа бахархдаг. Өөрөөр хэлбэл өөрт байгаа мөнгө, гадна төрх, нэр төр, эрх мэдэл нь Бурханаас илүүд тооцсон зүйлс юм.

Өмнөд Иудагийн хаант улсын 13дах хаан болох Хезекиа нь нэг хэсэг Бурханыг харахад зөв шудрага байж Бурханы өргөөг ариусгах тал дээр манлайлдаг байлаа. Түүний залбирлаар Ассирийн эзэнт гүрний их цэргийн дайралтыг няцааж, ялан дийлсэн бөгөөд үхэх хүнд өвчин туссан үедээ ч нулимс унаган залбирал хийж 15жил өөрийн насаа уртасгаж ч байлаа.

Гэтэл түүнд амьдралын бардам бахдал гэдэг зүйл үлдсэн байлаа. Түүний өвчин эдгэрсэн гэсэн мэдээ сонссон Вавилоны хаан элчээ илгээсэн юм. Сэтгэл нь ихэд хөдөлсөн Хезекиа Вавилоны элч нарт өөрийн алт эрдэнэс, эдэлж хэрэглэдэг бүх зүйлсээ үзүүлж гайхуулав. Эцэст нь тэрээр өөрийн эд юмсаа гайхуулсаны улмаас Вавилоны дайралтад өртөж тэгж их гайхуулаад бахархаад байсан эд зүйлсээ бүгдийг булаалгаж орхисон юм (Исаиа 39:1-6).

Энэ мэт бахархах сэтгэл хоосон ертөнцийн зүйл бөгөөд тэр хэмжээний Бурхан руу хандсан хайр байхгүйг илэрхийлдэг. Түүнчлэн сүнслэг хайр, жинхэнэ хайрыг бий болгохын тулд ертөнцийг хайрлах сэтгэлээс үүдэлтэй “Амьдралын бардам бахдал”-г хаях хэрэгтэй юм.

## 2. Бурханд алдрыг өргөдөг ‘Эзэн доторх бахархал’

2 Коринт 10:17 “Харин сайрхагч нь Эзэн дотор сайрхагчун” гэсэнчлэн Эзэн дотор сайрхал нь Бурханд алдрыг өргөдөг тул хичнээн л хийсэн сайн байдаг. Үүний нэг зүйл нь Эзэн доторх “Гэрчлэл” юм.

Элч Паул “Харин бидний Эзэн Есүс Христийн загалмайгаар сайрхахаас өөр нь надад бүү байг” (Галат 6:14) хэлсэн шиг биднийг аварч тэнгэрийн орныг өгсөн Есүс Христээр бахархах явдал юм. Гэмээс болж мөнхөд үхэхээс аргагүй байсан ба загалмай дээр бидний гэмийн өрийг өмнөөс нь төлж өгсөн Есүсийн ивээлээр мөнхийн амьдралыг авсан тул хичнээн талархалтай зүйл вэ? Элч Паул тэр ч байтугай өөрийн сул дорой байдлаараа ч бахархаж байсан юм.

2 Коринт 12:9 “Тэр надад Миний нигүүсэл чамд хангалттай. Учир нь мөхөс байдал дотор (Миний) хүч бүрэн төгс болно гэж айлдсан Иймд би ихэд баяртайгаар мөхөс байдлуудаараа илүү сайрхана. Ингэх нь Христийн хүч миний дотор оршихын тулд билээ” гэсэн билээ.

Өнөө үед олон хүмүүс амьд оршигч Бурхантай уулзаж мэдэрсэн тухай гэрчилдэг. Бурханыг чин сэтгэлээсээ эрэн хайж хайрласнаар өвчнөөсөө эдгэрч, эд хөрөнгийн ерөөл, эв нэгдэлтэй гэр бүл болоод Бурханыг гэрчилцгээж байдаг (Сургаалт үгс 8:17). Юуны түрүүнд Бурханы хайрыг мэдэрч, итгэлтэй болох зэрэг сүнс талын ерөөл авсан гэж гэрчилцгээдэг. Энэ мэт Эзэн доторх бахархал нь Бурхандаа алдрыг өргөх төдийгүй бусад хүмүүст ч итгэл болон амийг суулгаж өгдөг. Тэнгэрийн оронд шагнал хурааж зүрх сэтгэлийн хариултаа ч хурдан авдаг.

Гэтэл амаараа “Бурхандаа алдрыг өргөө” гэдэг ч өөрөөрөө бардамнах гэсэн тохиолдол байх тул үүнийг сайн ялгаж салгах хэрэгтэй. Өөрөө ч мэдэлгүй “Би ингэж хийсэн учраас ерөөл авлаа” ярьдаг Бурхандаа алдрыг өргөж мэт харагдаж байгаа ч өөрийн хийсэн зүтгэснээ л ил гаргаж байгаа хэрэг юм. Ийм хүн сатан уруу татлагад орох амархан байдаг. Өөрөөрөө бахархсаны үр дүн нь янз бүрийн том жижиг асуудлууд сорилтуудыг туулах, өөрийг нь ойлгож өгөхгүй бол Бурханаас холдон оддог.

Бурханыг жинхэнэ хайрладаг бол бүх зүйлд босгох урам өгөх үг, бусдад итгэл болон амь өгдөг үгийг хэлэх ёстой байдаг (Ром 15:2). Усны шүүлтүүрээр дамжуулан ус цэвэршүүлэгддэг шиг яаруу адгуу байдлаар үг хэлэх бус бусдад хэрхэн ашиг тустай болохыг бодолцож, магадгүй шарх болж болзошгүйг бодсоны дараа үг хэлэх хэрэгтэй юм.

## 3. Амьдралын бардам бахдал нь Тэнгэрийн орны тэмүүлэлээр дүүрч

Бахархах зүйл олонтой хүн ч мөнх амьдрах боломжгүй юм. Энэ газар дээрх амьдрал дууссаны дараа тэнгэрийн орон уу там уу гэсэн сонголтод тулж аль нэг рүү явах болдог. Тэнгэрийн оронд зам нь хүртэл шижир алт учир энэ газрын элбэг хангалуунтай зүйрлүүлшгүй бөгөөд энэ газар дээр бахархаж сайрхаж байгаа зүйл өчүүхэн бөгөөд ямар ч хэрэгцээгүй зүйлс юм.

Матай 16:26-27 “Учир нь хүн бүх дэлхийг олж


### Монгол Манмин Сүм

#### Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

#### Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00



**Хаяг:** Баянгол дүүрэг 16-р хороо Орхоны 1-33А Чуулганы ахлагч П.Батзориг  
**Утас:** 88107327, 91170773, 89737773

www.manmin.org  
www.gcntv.org

авсан ч амиа алдвал ямар ашиг байх билээ? Эсвэл амийнхаа оронд юугаа өгөх вэ. Учир нь Хүний Хүү тэнгэр элч нарын хамт Эцэгийнхээ алдрын дотор ирж, хүн бүрд үйлсийнх нь дагуу хариуг өгнө” гэжээ.

Энэ ертөнцийн бахархах зүйл нь эцэстээ мөнхийн амь эсвэл сэтгэл хангалуун байдлыг өгөх боломжгүй юм. Харин ч хоосон шуналыг бий болгож мөхлийн зам руу явах дөт зам болдог. Ийм үнэнийг ухаарч Тэнгэрийн орны хүсэл тэмүүлэл дотор үйлдвэл амьдралын бардам бахдалыг хаях хүчтэй болдог.

Гэрэлтэх тэнгэрийн орны эрдэнэс болон үзэсгэлэнтэй байдлыг итгэж энэ газар дээрх түр зуурын зүйлс сагаарах зав байдаггүй.

Бид бүхэн амьдралын бардам бахдалыг хаявал зөвхөн Есүс Христээр сайрхан бахархах болдог. Энэ ертөнцийн зүйлс нь бахархам зүйлс биш бөгөөд хожим тэнгэрийн оронд эдлэх алдар л жинхэнэ бидний бахархах зүйл юм. Өмнө нь мэдэхгүй байсан авралын баяр хөөрөөр өдөр бүр бялхаж, хэдийгээр янз бүрийн сорилтуудыг туулдаг ч хэцүү санагддаггүй.

Хайрт итгэгч та бүхэн, Цор ганц хүүгээ харамгүй зориулж өгсөн Бурханы хайр загалмайд цовдлогдох хүртлээ дуулгавартай байсан Эзэний хайр төгс бууж ирэх үед үргэлж баяртай байж, тасралтгүй залбирч, бүх зүйлд талархаж чаддаг юм. Амьдралын бардам бахдалыг хайх сэтгэл байхгүй бол магтаал авсан ч ганхалгүй, зэмлүүлсэн ч санаагаар унадаггүй. Сүнс талын хайрыг эзэмшиж даруухнаар өөрийгөө эргэн харж, олон хүмүүсийг авралын замаар удирдахыг Эзэний нэрээр хүсэн ерөөе.



Израйльп сайн мэдээ тарааж эхэлсэний 12жилийн ойн тусгай дугаар 1

## Эзэний зам мөрийг дагаад (1)

“Одоо инжрийн модноос сургаалт зүйрлэлийг сурч ав.

Инжир модны мөчир хэдийнээ зөөлөрч, навчсаа зулзаглуулахад зун ойртжээ гэдгийг та нар мэддэг. Түүнчлэн та нар энэ бүхнийг хараад, Түүнийг ойрхон байгааг та нар бас мэдэгтүн” (Матай 24:32-33).

Инжрийн мод нь сүнс талаар Израйлыг илэрхийлдэг. Христчин <Сэргэлт> баримтат кинон дээр инжрийн мод зөөлөрнө гэдэг нь гэжүүд Израйльчууд иудей хүмүүс зүрх сэтгэлээ нээж сайн мэдээг хүлээн авах тухай, “Навчсаа зулзаглуулана” гэдэг нь Мессиа төвтэй чуулганы сэргэлтийн үе гэсэн байдаг.

1982онд сүм байгуулагдсанаас хойш Бурхан Ариун Сүнсний бялхам байдал дотор Израйлийн тухай олон зүйлсийг илчилж өгсөн юм. Израйлийн тусгаар тогтнол нь эцсийн үеийн шинж тэмдэг бөгөөд библид тэмдэглэгдсэн зөгнөлийн биелэл хэсэг юм. Иеремиа 31:10д “Үндэстнүүд ээ, Эзэний үгийг сонсож, алс холын эргүүдэд тунхаглан, Израйлыг тараасан Нэгэн түүнийг цуглуулан, хоньчин хонин сүргээ хамгаалдаг шиг түүнийг хамгаална гэ хэлцгээ” гэсэнчлэн Израйль нь1948тусгаар тогтнолоо зарласан юм.


Бурхан хүн төрөлхтөнийг бүтээж, дасгалжуулж буй зорилгыг мэдүүлэх гэж Израйль ард түмнийг зорьсон байдаг. Израйль Бурханы хүсэл дунд байхдаа агуу үндэстэн гэж нэрлэгдэх хэмжээний агуу сүр жавхланг эдэлж байлаа. Эсрэгээрээ Бурханаас холдож дуулгаваргүй байх үед эргэн тойрны улс үндэстнүүдийн дайралт болон маш их зовлонг эдэлж байлаа.

Гэхдээ Израйль нь гэмийн улмаас хүнд байдалд орохдоо ч Бурхан тэднийг мартаж орхиогүй юм. Энэ мэт Бурханы онцгой хамгаалалт болон удирдамж байсан тул Израйль үргэлж оршин байсаар эцэстээ тусгаар тогтносон юм.

### \* Израйлийн тусгаар тогтнол нь эцсийн үеийн шинж тэмдэг

Олон хүмүүс “Иудейчүүдийн оршин байгаа нь гайхамшиг” гэж хэлдэг. Иудей үндэстэн дэлхий өнцөг булан бүрт тарж бутран тэднийг хавчин гадуурхах явдал бидний төсөөлсөнөөс ч хэцүү байсан ч Израйлыг түүхийг л харахад Библи бол үнэн гэдгийг дахин баталдаг. Гэтэл иудейчүүдийн авч байсан дарамт шахалтаас илүү аймшигтай гай зовлон Эзэн залран ирсэний дараа эхлэх юм.

2000д жилийн өмнө Израйль газар дээр ирсэн Есүсийг өөрийн аврагчаар хүлээн авсан хүмүүс Эзэнтэй хамт дээш өргөгдөж, агаар мандалд хурим найранд оролцох хэдий ч тэгж чадаагүй хүмүүс нь



дээш явалгүй энэ газарт үлдэн 7жилийн гай зовлонг амсах болно.

Бурхан эцсийн энэ үед Израйльд санй мэдээ тараах тухай мэдүүлж өгч эцэстээ иудей хүмүүс ч гэмшиж эргэх сайн мэдээний эргэлт бий болох тухай айлдаж байгаа юм. Тэгээд 1989онд эхлэсэн Израйль даяар хийсэн ариун аялал болгондл Бурхан тод онгод дотор яг библи дотор бодит байдал руу орж байгаа мэт маш сэтгэл хөдлөм байдлыг өгч байлаа.

Египетээр дамжин Израйльд хүрсэн аялалын багийнхан Сөнөсөн тэнгисийн орчим нэг өдрийг өнгөрөөсөний дараа маш их хүлээлт болон сэтгэл хөдлөл дотор Израйлын хойд хэсэг Галил нуур руу чиглэн явсан юм.

Ой модоор битүү өндөрлөг газар маш үржил шимтэй тэгш тал газарт орших далай мэт өргөн уудам Галил нуур нь Есүсийн үйлчлэлийн эхэн үеийн чухал газар ч гэгддэг.

Есүс Галилийн эрэг дээр шавь нараа дуудаж, сайн мэдээг тарааж, үйл олон хүмүүсийг тэмдэг гайхамшигийг үйлдсэн юм. Галил нуур руу ирж очин, гайхамшигт хүч чадлаар салхи болон давалгааг нам гүм болгож, усан дээр хүртэл алхаж байлаа.

Аялалын багийнхан Галилийн эрэг дээр олон газар Есүсийн ул мөрийн хараад сэтгэл хөдлөлийн нулимсаа барьж дийлээгүй юм.



Арваад жилийн өмнө миний баруун чих сайн сонсохгүй болсон юм. Хүмүүстэй ярих, харилцах тал дээр маш хэцүү буруу ойлгох тохиолдол ч хааяа гардаг байлаа. 2018он 11-р сард сонсголын аппарат байнга зүүж байхыг эмч зөвлөсөн юм.

Эзэний хүч чадлаар эдгэрье гэж би өөрийн итгэлийн амьдралаа эргэн харав. 2008оны 1-р сард архагшсан тархины судасны нарийсалын улмаас бие маант маш зовиуртай өдөр тутмын амтэрал маш хэцүү байх үед Монгол Манмин цуглаанаас сонсогдох магтан дууг сонсон цуглаанд очсоноор тэндээ бүртгүүлсэн юм.

Тэгээд 4-р сард болсон Эдгэрэл ивээлийн цуглаанд И Жей руг пасторын залбирч өгсөн эрх мэдэлт хүчтэй гар алчуур (Үйлс19:11-12)-аар залбирал авч тархины судасны нарийсал болон ганихрах өвчнөөсөө эдгэрсэн юм.

Энэ мэтчилэн Бурханы агуу хүч чадлыг мэдэрсэн чихний сонсголоос эдгэрч чадахгүй байгаа тул энэ удаад итгэлээрээ зайлшгүй эдгэрье гэж шийдсэн юм. Тэгээд 5-р сард Солонгост байх Манмин Төв сүмээс сайн мэдээний багийнхан ирнэ гэдгийг сонсоод хариулт авах боломж гэж бодон итгэлээрээ бэлдэж эхлэв. Би библийг дахин бүтэн уншъя мөн сүмийн гал тогооны үйлчлэл зэрэгтээ хичээнгүйлэн зүтгэж, Бурханыг баярлуулж болох үйлсийг хайж хийж байлаа.

Тун ч удалгүй 5-р сарын 17ны өдөр Улаанбаатар Манмин цуглаанд Эдгэрэл ивээлийн цуглаан нээгдэж уг цуглааны номлогч И Ми ён пастор гар алчуурын



## “Чихний сонсгол болон элэгний хатуурал, бүр цусны даралт ихдэх өвчнөөсөө эдгэрсэн”



Хоролмаа Туяа туслагч  
(58нас, Монгол, Улаанбаатар Манмин цуглаан)

залбирал авах бүх биеэр халуу шатаж байлаа. Зүүн чихээ таглаж баруун чихээр сонсож үзтэл өмнөхөөсөө илүү сайн сонсдог болсон ба цаашид бүр сайжирсан

юм. Одоо маш тод сонсдог болсон ба зүүн чих ч өмнөхөөсөө илүү сайн сонсдог болсон юм.


Ялангуяа элэгний хатуурлын улмаас

жоохон л ядрах юм бол гэдэс минь хөөж яг жирэмсэн мэт том болдог байсан ба энэ удаагийн эдгэрэл ивээлийн цуглаан элэгний хатуурал өвчин минь өмнөхөөсөө сайжирч, даралтны эм хүртэл уухгүй хэмжээнд хүртэл бие минь сайжирч хөнгөрсөн юм.

Мөн миний бага охин (Энхзаяа, зураг) бөөрний хурц үрэвсэлийн улмаас нуруу бүсэлхий хавиар их өвдөж өглөөдөө халуурч сайн босож чаддаггүй байсан юм.

Гэтэл 2019оны эхний Зудаагийн онцгой залбиралд оролцон чин сэтгэлээсээ залбирахад Ариун Сүнсний галаар бөөрний үрэвсэлээсээ эдгэрсэнээ мэдэж, сүүлийн өдөр 3-р сарын 31ний өдөр тэргүүн пасторын ерөөлийн залбирал авч илүү төгс эдгэрсэн юм.

Эрүүл мэндийн асуудлыг шийдэж, надад шинэ итгэлийг өгс үгээр илэрхийлэхийн аргагүй баяр хөөрөөр бялхааж өгсөн Бурхан Аавдаа, хайрт Эзэндээ бүх талархал ба аодрыг өргөө.



## “Цөхрөл дунд байсан би Эзэнтэй уулзаж, ерөөлийн Эзэн болсон”

Жон Ми суг туслагч (58нас, 3-р их бүлэг 24-р хэсэг)

Эзэн дээр ирэхээс өмнө миний амьдрал тэр чигтээ цөхрөл гуниг байсан юм. 1993онд эрхэлж байсан бизнес маань дампуурч түүнээс маш их өрөнд орж бид зэрэг зэрэг ажиллан өрөө төлж байсан ч хүчрэхгүй л байлаа.

Нэгэн өдөр “Бурхан, минь би дампуурахынхаа өмнөх үе рүү очиж болдог үнэхээр хичээнгүйлэн амьдарнаа” гэж залбирч байлаа. Сүмд ганц ч удаа очиж үзээгүй би тэр хэмжээний цөхөрсөн байв. 1997оны 3-р сард би таньдаг хүнийхээ урилгаарМанмин төв сүмд ирсэн юм.

Сүмд анх ирэхэд итгэгч нарын аз жаргалтай төрх, ивээл дүүрэн магтаал, сургаал зэрэг яг л тэнгэрийн оронд орж ирсэн мэт санагдаж байлаа. Өрийн дарамтанд шахагдан байсан ч сүмд л ирвэл сэтгэл нэг л сайхан тайван, би өөрчлөгдөх тусам нөхөр Паг Жун мин ч гэсэн сүмд ирдэг болсон юм.

Хүмүүсийг өөрөөсөө ч илүү хайрлах И Жей руг тэргүүн пасторын амьдралаас ивээл авч, үй олон итгэгч нар мөн тэргүүн пасторын залбирлаар эдгэрч байгааг хараад итгэлтэй болсон манай гэр бүл нурууны диск өвчнөөсөө эдгэрсэн юм.

Би зам дээр цэцгийн худалаа эрхэлж, нөхөр маань ч мөн гудамжны наймаа хийж өрнийхөө ихэнх хэсгийг төлж, нэгэн дэлгүүр олж хамтаа наймаагаа өргөжүүлэх хүсэлтэй болсон юм. Тэгээд хуримаа хийгээд 17жилийн болсон бөгжөө талархалын өргөлд өргөн итгэлээрээ залбирал авсан юм.

2003онд Бурхан хариулж нэгэн дэлгүүртэй болж будаа зардаг болсон юм. Түүний дараахан төрөл бүрийн ногооны дэлгүүр ажилуулан бүх өрөө дарж дуусгасан юм.

Мөн дэлгүүртэй амьдардаг байсан бид Зорон байрын төлөө залбирсан ба 2017 онд маш таатай нөхцөлөөр орон сууцтай болох ерөөлийг авсан юм.

Гэтэл 2018оны 3-р сард манай дэлгүүрийн эсрэг талд жимс ногооний төрөлжсөн дэлгүүр нээгдэхэд сэтгэл тайван байж чадсангүй. Гэвч “Бурхан минь энэ дэлгүүрийг ч сайн борлуулттай манай дэлгүүр ч бас амжилттай болгож өгөөрэй” гэж залбирсан юм. Тэгтэл гайхамшигтай нь Исаа 200,300 байсан өдрийн орлого 2 саяас дээш болж, байнгын үйлчлүүлэгчтэй болсон юм. Халлелуяа!

Юуны түрүүнд Эзэн дотор эв нэгдэлтэй гэр бүл болгож, охин Паг Ёон ён “Хайр бүжгийн баг”-т үйлчилж хүү Паг Ёон сү саяхан ажилдаа дэвших ерөөл авсан юм. Ивээлээр арвин дүүрэн Бурхандаа бүх алдар талархлыг өргөө.

### УБ Ариун баярт мэдээ чуулган

#### Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

#### залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

#### Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

## Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс

Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-818-7048

http://www.manmin.org/english

www.manminnews.com

e-mail: manminninen@manmin.kr

Нийтлүүлэгч: Жаерок Лее